



ТИ ЭЛ ПРОЖЕКТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.БАЯРТ ТАНАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7799 0101

Цахим шуудан: ubhd@emg.ub.gov.mn
Цахим хуудас: www.ubhealth.mn

2024.06.14 № 10-13-02/043/424

**Зураг төсөлд эрүүл ахуйн
хяналт хийсэн тухай**

Тус байгууллагад ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5.1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх” тухай 10-00/02 тоот удирдамжийн дагуу Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн Засаг даргын тамгын газрын захиалгаар баригдах үйлчилгээний барилга, тохижилт, ногоон байгууламжийн ажлын зураг төсөл, холбогдох бичиг баримтын бүрдэлд 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр эрүүл ахуйн хяналт хийлээ.

Нэг. Барилгын зураг төслийн нэр, боловсруулалт:

Нийслэлийн ерөнхий архитекторын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн МЗХ2024/00-309 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавартай.

Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээц, цэвэр, бохир ус, халаалт, агаар сэлгэлтийн ажлын зургийг ЗТ18-130/23 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Ти эл прожект ХХК-д боловсруулсан, ТЛ-09/24 шифртэй ажлын зураг төсөл.

Хоёр. Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/489 дугаар захирамжаар Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн Засаг даргын тамгын газарт 1461503458 нэгж талбарын дугаартай, 10075 м.кв газрын 15 жилийн хугацаатайгаар худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмших эрх олгосон байна.

1550001290

Гурав. Барилгын ажлын зураг төслийн төлөвлөлт:

3.1 Төлөвлөж буй барилга нь тэнхлэгээрээ 67.0х29.0м хэмжээтэй, даацын тоосгон өрөгт бүтээцтэй, 2 давхар барилга. Үүнд:

Барилгын 1 дүгээр давхрын 15 м.кв, 17 м.кв, 19 м.кв, 20 м.кв, 32 м.кв талбайтай үйлчилгээний 22 өрөө, 9-10 м.кв, 14-16 м.кв талбайд эр, эм, тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө, 7-54 м.кв талбайд холбооны, цахилгааны, сэнсний, узелийн, үйлчлэгчийн өрөө байхаар;

Барилгын 2 дугаар давхрын 13 м.кв, 18 м.кв, 22 м.кв, 68 м.кв, 84 м.кв талбайтай үйлчилгээний 8 өрөө, 9-18 м.кв талбайд эр, эм ариун цэврийн өрөө, 19-87 м.кв талбайд кофе шоп, агуулахын, сэнсний өрөө байхаар;

Барилгын техникийн давхрын 48 м.кв талбайд хонгил, техникийн өрөө байхаар тус тус төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлт, гэрэлтүүлэг: Барилгын зориулалт технологиос хамааран механик систем, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хосолсон байхаар төлөвлөсөн.

Цэвэр ус хангамж, ариутгах татуурга: УСУГ-ын техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 205/24 дугаартай техникийн нөхцөлтэй.

Цахилгаан хангамж: Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 01/01633/24 дугаартай техникийн нөхцөлтэй.

Инженер геологийн судалгаа: Барилгын инженер-геологийн судалгааг 2024 онд Лэнд тест ХХК гүйцэтгэж, дүгнэлтэд судалгааны талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй, газар хөдлөлтийн 8 баллын бүсэд багтдаг, улирлын хөлдөлтийн гүн 2.46-3.51 м, судалгааны талбайд хөрсний ус 4,2-4,5 метрийн гүнд илэрч тогтсон гэж дурдсан байна.

Цаашид барилгын угсралтын ажил эхлэхээс өмнө ажлын зурагт дараах асуудлыг тусгах шаардлагатай:

1. Барилгын ариун цэвэр, эрүүл ахуйн нормын шаардлагын дагуу хог хаягдлыг цуглуулж хадгалах, зайлуулах талаар тусгах.

2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх.

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг үндэслэн **ДҮГНЭХ НЬ:**


Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Нийслэлийн Засаг даргын тамгын газрын захиалгаар баригдах үйлчилгээний барилга, тохижилт, ногоон байгууламж нэртэй, ТЛ-09/24 шифртэй барилгын ажлын зураг төсөл нь

Монгол Улсын Барилгын дүрэм. Олон нийт, иргэний барилга БНБД 31-03-03 төлөвлөлтөд заасан эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  М.ОТГОНБАЯР

ХҮЛЭЭН АВСАН:


.....
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

Аж ахуй нэгж, иргэний тайлбар

.....
.....

Улсын байцаагчийн тайлбар

.....
.....